

# Хана

Нэгэн компани янз бүрийн  $n$  ширхэг хамгаалалтын **хана** барьжээ. Бяцхан нууцлал хийх үүднээс  $n$  ширхэг ханын мэдээллийг  $n \times n$  хэмжээст хүснэгтэд хадгална. Жишээ нь:

1 3 1

2 1 3

3 2 2

гэсэн мэдээлэлд 1 дугаартай хананд гурван багана тоосго өрсөн ба 1-р баганын өндөр  $b[1]=3$ , 2-р баганын өндөр  $b[2]=2$ , 3-р баганын өндөр  $b[3]=3$ . Өөрөөр хэлбэл 1 дугаартай хананы 1-үүд нь 1-р багананд 3 өндөрт, хоёрдугаар багананд 1-н тоо хоёр өндөрт, гурав дугаар багананд 3 өндөрт тус тус байрласан. Үүнтэй адил 2 болон 3-р ханын мэдээллийг олно. Мөн хананы тодорхойлох шинжийг нэмэлтээр өгдөг байв. Тухайлбал **эрс хотгор** гэдэг нь хөрш гурван баганаар тодорхойлогдох бөгөөд

$b[i-1] > b[i]$  ба  $b[i] < b[i+1]$  нөхцөл хангана.  $n$  тоо өгөгдөхөд ямар нэг  $m$  дугаартай ханын эрс хотгорын тоог **хурдан хугацаанд** тооцоолно уу.

**Оролт:** Нэгдүгээр мөрөнд  $n$ ,  $m$  ( $1 \leq m \leq n \leq 1000$ ) хоёр тоо, дараах  $n$  мөр  $n$  багананд ханын мэдээлэл болох тоонууд (1-с  $n$ -ийнхооронд байх тоо) өгөгдөнө. Ханын багана дахь тоо давхцахгүй.

**Гаралт:** Эрс хотгорын тоог илэрхийлэх зөвхөн ганц тоо байна.

**Жишээнүүд:**

Оролт	Гаралт
3 1 1 3 1 2 1 3 3 2 2	1
5 5 1 2 4 3 4 2 3 2 5 1 4 4 3 1 3 5 1 1 4 2 3 5 5 2 5	0